



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/376

Мандалговь

“С.Буяннэмэх тэмдэгтэн” тэмдэг,  
үнэмлэх хийлгэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2018 оны А/226 дугаар захирамжаар батлагдсан “С.Буяннэмэх тэмдэгтэн” шалгаруулах журмын 4 дүгээр бүлгийн 4.1, 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүүхэд, өсвөр үеийнхний ном унших хүсэл сонирхлыг өрнүүлэн, тэднийг номтой нөхөрлүүлж, ном уншигчдын тоог нэмэгдүүлэх, оюуны бүтээлийг зорилгоор “С.Буяннэмэх тэмдэгтэн”-ий болзол хангасан уншигчдад олгох “С.Буяннэмэх тэмдэгтэн” тэмдэг, үнэмлэх хийлгэхэд хөрөнгө гаргасугай.

Хоёр. Тэмдэг, үнэмлэх хийлгэх зардлыг нэгдүгээр хавсралтаар, “С.Буяннэмэх тэмдэгтэн” тэмдэг, үнэмлэхний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тэмдэг, үнэмлэх хийлгэх зардалд 650000 (Зургаан зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

Дөрөв.Тэмдэг, үнэмлэхийг батлагдсан загварын дагуу өнгө үзэмж сайтай, чанартай хийлгэж, хүлээн авахыг аймгийн Төв номын сан (Ц.Одончимэг)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191060


Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 27-ны өдрийн 376 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



“С.БУЯННЭМЭХ ТЭМДЭГТЭН” ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХ ХИЙЛГЭХ ТӨСӨВ

Д/д	Зардлын утга	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1.	“С.Буяаннэмэх тэмдэгтэн” тэмдэг	6000	100	600000
2.	Үнэмлэх	500	100	50000
	ДҮН			650000

Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 10-ны өдрийн 136 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



"С.БУЯННЭМЭХ ТЭМДЭГТЭН" ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

